

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## 1. Агуулга

Аудитын гэрчилгээ.....	2
Аудитын тайлан .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	18
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.09.20 № 06/540  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн.

Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Алтанбулагийн чөлөөт бүс нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон бусад стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирагч Ж.Амаржаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн жолоочийн замын хуудас хөтлөх, шатахуун зарцуулалтыг машины гүйлтээр хянаж байх, дотоод хяналтыг сайжруулах болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-нөөс 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний Аудитын Газрын захиалгаар “Пийк Ом Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Пийк Ом Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 13-ны 01/49 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Алтанбулагийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрх зүй, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлснээр экспорт, импортыг дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, транзит тээвэр, логистикийг нэмэгдүүлэх, тэргүүний техник, технологийг нутагшуулах, худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн хөгжлийг хурдасгах замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх”-д оршино.

Алтанбулагийн чөлөөт бүсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасах;
- Чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох;
- Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, тамхи худалдах, эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу олгох;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээтэй холбоотой;
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, илүү цагийн нэмэгдэл хөлс олгох, ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой;
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад шагнал, урамшуулал олгохтой холбоотой.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Алтанбулагийн чөлөөт бүсийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Алтанбулагийн чөлөөт бүс нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Си Ти Эс” програм хангамж ашигладаг бөгөөд Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгээс шаардлага хангасан гэсэн үнэлгээг авчээ.

Алтанбулагийн чөлөөт бүсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Алтанбулагийн чөлөөт бүсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,693,455.0 мянган төгрөгөөс тооцон 16,934.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 18,349.0 мянган төгрөгөөр тооцсон нь Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,834,739.8 мянган төгрөгийг суурь үзүүлэлт болгон сонгосонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,414,944.0 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	125,938.6	72,200.1	-53,738.5
Авлага	1,177,086.6	809,899.0	-367,187.6
Урьдчилгаа			
Бараа материал	10,152.7	11,857.6	1,704.9
Үндсэн хөрөнгө	24,193,075.7	23,197,352.8	-995,722.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>25,506,253.6</b>	<b>24,091,309.5</b>	<b>-1,414,944.1</b>
Өр төлбөр	73,579.7	72,364.1	-1,215.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	25,432,674.9	24,018,945.4	-1,413,729.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>25,506,254.6</b>	<b>24,091,309.5</b>	<b>1,412,945.1</b>

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 53,738.5 мянган төгрөгөөр буурсан нь урьд оны техник хяналтын дансны үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

Авлага дансны үлдэгдэл 367,187.6 мянган төгрөгөөр буурсан нь Алтанбулагийн чөлөөт бүсэд хөрөнгө оруулалтын болон газар эзэмших гэрээтэй байсан 30 ААН-ийн 331,810.8 мянган төгрөгийн газрын төлбөрийг анхан шатны шүүхийн шийдвэрийг үндэслэн холбогдох байгууллагуудад хандаж шийдвэр гаргуулсны дагуу тус бүсийн захирагчийн 2019 оны А/59, А/69 дугаар захирамжуудаар хэрэгсэхгүй болгосонтой холбоотой. Мөн тайлант онд 35,376.8 мянган төгрөгийн авлагыг нэхэмжилж барагдуулсан байна.

Авлага дансны эцсийн 809,899.0 мянган төгрөгийн үлдэгдлийн 141,119.3 мянган төгрөгийн авлага нь 1-5 жилийн, 668,779.7 мянган төгрөгийн авлага нь 5-аас дээш жилийн насжилттай бөгөөд чөлөөт бүсийн дэд бүтцийн асуудал бүрэн шийдэгдээгүй, үйл ажиллагаа явуулаагүй зэргээс газар эзэмших эрх нь цуцлагдсан ААН-ийн газрын төлбөрийн авлага байна. Энэ нь авлага барагдуулах талаар шүүхийн байгууллагад хандахад хөөн хэлэлцэх

хугацаа дууссан, улмаар найдваргүй авлагын хэмжээ нэмэгдэх сөрөг үр дагавар бий болгосон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 12 дугаар сард ажилтнууд албан томилолтоор орон нутагт ажиллаагүйгээс 255.0 мянган төгрөгийн шатахуун, 204.6 мянган төгрөгийн тусгай зөвшөөрөл, гэрчилгээний үнэт цаас, ажилтнуудын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа бусад хангамжийн материалын үлдэгдэл нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тайлант онд 1,200.0 мянган төгрөгөөр архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамж худалдан авч биет бус хөрөнгөөр бүртгэжээ.

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 1,379.6 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж үлдэгдэл 1,215.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитаар цалингийн санг Татварын байгууллагад дутуу тайлагнаж, ажилтнуудаас суутгасан ХХОАТ-ыг дутуу шилжүүлсэн зөрчлийг илрүүлж санхүүгийн тайланд залруулга хийлгэснээс 164.1 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдлээр бүртгэгдсэн 72,200.0 мянган төгрөг нь дэд бүтцийн ажил хийж гүйцэтгэсэн компанийн гүйцэтгэлийн баталгааны барьцаа хөрөнгө бөгөөд нийт өр төлбөрийн 99.8 хувийг эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 24,018,945.4 мянган төгрөг болж 1,413,729.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Алтанбулагийн чөлөөт бүс нь тайлант онд газрын төлбөрт 116,856.9 мянган, тусгай зөвшөөрөл, төсөл сонгон шалгаруулалт, зааварчилгааны хураамж зэргээс 30,024.9 мянган төгрөгийг бүрдүүлж улсын төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 640,101.6 мянган төгрөгийн урсгал зардлын төсөв батлагдсан байна.

Нийт зардлын 640,101.6 мянган төгрөгийг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөж санхүүжилтийг бүрэн авч зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 586,018.6 мянган төгрөг буюу 91.5 хувьтай байгаа нь цалин хөлс ба нэмэгдэл урамшууллын зардал 47,442.2 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 5,599.1 мянган, байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 518.5 мянган, хангамж бараа материалын зардал 67.7 мянган, эд хогшил, урсгал засварын зардал 4.9 мянган, дотоод албан томилолтын зардал 23.3 мянган, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр 423.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 4.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнээс шалтгаалсан байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.



Аудитаар нийт 7,756.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,858.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,898.1 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, зөрчил арилгуулах 1 албан шаардлага хүргүүлж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчдын цалин нэмэгдэл хөлсний асуудлыг шийдвэрлэх зэрэг 2 зөвлөмж өглөө. Үүнд:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилттэй холбоотой 1,200.0 мянган, цалингийн зардалтай холбоотой 2,494.3 мянган, ХХОАТ-ын өглөгтэй холбоотой 164.1 мянган төгрөг нийт 3,858.4 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн болно.

1.Ээлжийн амралтыг биеэр эдлээгүй ажилтнуудад 3,898.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д *“Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”*, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан *“Ээлжийн амралт олгох заавар”*-ын 13-т *“Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх, төлбөрийн акт тогтоох

2. Алтанбулаг чөлөөт бүсийн тооцооны тооцооны нягтлан бодогч нь 2019 оны 01 дүгээр сараас хойш эд хариуцагчийн үүргийг Хөдөлмөрийн гэрээгүй гүйцэтгэж, анхан шатны баримтууд дээр нягтлан бодогч, олгосон нярав хэсгүүдэд гарын үсэг зурсан зөрчил гаргасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгөх

### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

“Дархан Сэлэнгийн Цахилгаан түгээх” ХХК нь Алтанбулагийн чөлөөт бүсийн дэд станц, шугам тоноглолоор дамжуулан чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг ААН-ийг цахилгаан эрчим хүчээр хангадаг бөгөөд 2019 оны жилийн эцэст “Халиун уул чөлөөт бүс” ХХК-ийн цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэл 644.9 мянган төгрөгийг Алтанбулагийн чөлөөт бүстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Иймд чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн цахилгаан эрчим хүчний тооцоог тусад нь хийлгэх арга хэмжээг авч асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Алтанбулагийн чөлөөт бүс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 128 мэдээллийг хугацаанд нь, 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хугацаа хоцроосон шалтгааныг тодруулбал шилэн дансны цахим систем 2019 оны эхний улиралд засвартай байсан байна.

### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 374,066.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоосноос 5,035.4 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан, 369,031.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлснээс 369,031.4 мянган төгрөгийн 3 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Анхан шатны шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон ААН-ийн авлагыг харьяалах дээд байгууллагад хандаж найдваргүй авлагын нөөц дансанд бүртгэх талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 57.6 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

##### **“Зөрчилгүй” дүгнэлт**

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. **Дотоод хяналттай холбоотой асуудал**

##### 1.1. Илрүүлэлт:

Шатахууныг шаардах хуудсаар олгодог боловч жолоочийн замын хуудсаар зарцуулалтыг тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, холбогдох хууль тогтоомж зөрчигдөх

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Жолоочийн замын хуудас хөтлөх, шатахуун зарцуулалтыг машины гүйлтээр хянаж байх

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх зөрчлийг гаргахгүй ажиллана.

#### 2. **Тэтгэвэрт гарсан албан хаагчдын цалин хөлстэй холбоотой асуудал**

##### 2.1. Илрүүлэлт:

Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчдыг урьд хашиж байсан албан тушаалд эргүүлэн томилж цалин, нэмэгдэл хөлсийг хэвээр олгож байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4-д заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Хууль тогтоомж зөрчигдөх;

2.3. Өгсөн зөвлөмж

Тэтгэвэрт гарсан албан хаагчдыг ажиллуулах зайлшгүй шаардлагатай бол хөдөлмөрийн гэрээ байгуулж цалин хөлсийг тогтоох

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид дээрх зөрчлийг гаргахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,313,177,853.09</u></b>	<b><u>893,956,700.55</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	125,938,585.00	72,200,058.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	125,938,585.00	72,200,058.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	125,938,585.00	72,200,058.00
31211	Төрийн сангийн харилцах	125,938,585.00	72,200,058.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,177,086,554.12	809,899,027.12
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,177,086,554.12	809,899,027.12
3351	Байгууллагаас авах авлага	1,177,086,554.12	809,899,027.12
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	10,152,713.97	11,857,615.43
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	10,152,713.97	11,857,615.43
35410	Бичиг хэргийн материал	345,300.00	204,600.00
35440	Түлш, шатах тослох материал	35,850.82	255,055.28
35470	Бусад хангамжийн материал	9,771,563.15	11,397,960.15
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,193,075,727.34</u></b>	<b><u>23,197,352,828.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	24,193,075,727.34	23,197,352,828.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	19,059,789,360.60	18,015,066,461.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	18,937,197,627.64	18,937,197,627.64
39202	Хуримтлагдсан элэгдэл	(566,086,495.12)	(1,556,253,984.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,000,000.00	23,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,000,000.00)	(23,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	387,804,621.62	387,804,621.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(84,098,395.27)	(133,302,998.59)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,053,044.85	85,053,044.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,147,008.12)	(62,497,814.08)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	357,065,965.00	357,065,965.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	5,133,286,366.74	5,182,286,366.78
39301	Програм хангамж	2,500,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,633,333.26)	(2,033,333.22)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,430,982,200.00	5,430,982,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(298,562,500.00)	(250,362,500.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>25,506,253,580.43</u></b>	<b><u>24,091,309,529.01</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>73,579,658.50</u></b>	<b><u>72,364,137.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	73,579,658.50	72,364,137.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	73,579,658.50	72,364,137.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	164,079.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	72,200,058.00	72,200,058.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,379,600.50	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,379,600.50	-

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>25,432,673,921.93</u></b>	<b><u>24,018,945,392.01</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	25,432,673,921.93	24,018,945,392.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,542,753,318.00	6,542,753,318.00
51101	Өмч: - төрийн	6,542,753,318.00	6,542,753,318.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	18,568,839,640.99	17,155,111,111.07
51210	Өмнөх үеийн үр дүн	18,568,839,640.99	18,568,839,640.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,413,728,529.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	321,080,962.94	321,080,962.94
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>25,506,253,580.43</u></b>	<b><u>24,091,309,529.01</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>832,638,883.00</b>	<b>752,986,140.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>151,626,560.00</b>	<b>112,884,740.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	151,626,560.00	112,884,740.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	136,411,560.00	112,884,740.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	136,411,560.00	112,884,740.50
120009	Бусад орлого	15,215,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>681,012,323.00</b>	<b>640,101,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,012,323.00	640,101,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	610,119,500.00	640,101,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	70,892,823.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,693,455,017.41</b>	<b>1,834,903,900.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,693,455,017.41</b>	<b>1,834,903,900.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,522,718,918.22</b>	<b>1,578,100,758.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>359,146,088.01</b>	<b>392,768,312.50</b>
210101	Үндсэн цалин	331,059,088.01	363,748,312.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,087,000.00	29,020,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,170,795.50</b>	<b>49,395,948.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,443,294.61	34,557,107.66
210202	Тэтгэмжийн даатгал	3,677,942.55	4,065,541.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,871,314.03	3,129,553.39
210204	Ажилгүйдлийн даатгал	661,577.81	694,888.07
210205	Эрүүл мэндийн даатгал	6,516,666.50	6,948,857.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>57,198,186.00</b>	<b>66,753,502.00</b>

210301	Гэрэл, цахилгаан	51,782,361.00	55,890,800.00
210302	Түлш, халаалт	1,655,825.00	6,612,702.00
210303	Цэвэр, бохир ус	3,760,000.00	4,250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,596,720.67</b>	<b>9,513,622.36</b>
210401	Бичиг хэрэг	3,543,567.50	2,430,290.00
210402	Тээвэр, шатахуун	5,435,926.67	4,864,595.54
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,417,226.50	2,018,736.82
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,828,296.00</b>	<b>12,920,308.00</b>
210604	Урсгал засвар	13,828,296.00	12,920,308.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,067,216.00</b>	<b>2,906,280.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,067,216.00	2,906,280.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>58,531,120.00</b>	<b>46,149,886.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	48,054,830.00	37,281,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	312,390.00	306,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,700.00	191,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,344,900.00	1,938,800.00
210807	Газрын төлбөр	416,200.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,050,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,161,100.00	2,398,962.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>971,180,496.04</b>	<b>997,692,898.88</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	770,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	970,430,496.04	996,922,898.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,736,099.19</b>	<b>256,803,141.58</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>32,780,447.00</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,780,447.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,463,863.00</b>	<b>2,100,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,463,863.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>111,491,789.19</b>	<b>254,703,141.58</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,491,789.19	254,703,141.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(860,816,134.41)</b>	<b>(1,081,917,759.92)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,426,567,684.68</b>	<b>331,810,770.00</b>
225002	Найдваргүй авлагын алдагдал	-	331,810,770.00

225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	3,426,567,684.68	-
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(3,426,567,684.68)	(331,810,770.00)
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(4,287,383,819.09)</u></b>	<b><u>(1,413,728,529.92)</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>744,865,409.00</u></b>	<b><u>786,983,297.00</u></b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>63,853,086.00</b>	<b>146,881,897.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	63,853,086.00	146,881,897.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	61,238,086.00	146,881,897.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	61,238,086.00	146,881,897.00
120009	Бусад орлого	2,615,000.00	-
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>681,012,323.00</b>	<b>640,101,400.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	681,012,323.00	640,101,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	610,119,500.00	640,101,400.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	70,892,823.00	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>735,647,009.00</u></b>	<b><u>839,521,824.00</u></b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>735,647,009.00</b>	<b>839,521,824.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>564,910,909.81</b>	<b>582,718,682.42</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	359,698,500.90	392,594,643.39
210101	Үндсэн цалин	286,271,000.90	290,446,666.39
210102	Нэмэгдэл	45,300,800.00	73,283,977.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,126,700.00	28,864,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,598,628.41	49,405,538.71
210201	Тэтгэврийн даатгал	31,835,265.00	34,558,706.18
210202	Тэтгэмжийн даатгал	2,751,986.31	4,063,941.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,491,800.89	3,132,113.48
210204	Ажилгүйдлийн даатгал	912,894.53	695,525.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,606,681.68	6,955,252.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	57,198,186.00	66,753,502.00



210301	Гэрэл, цахилгаан	51,782,361.00	55,890,800.00
210302	Түлш, халаалт	1,655,825.00	6,612,702.00
210303	Цэвэр, бохир ус	3,760,000.00	4,250,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,065,973.50</b>	<b>9,647,126.82</b>
210401	Бичиг хэрэг	2,364,947.00	2,344,590.00
210402	Тээвэр, шатахуун	5,083,800.00	5,083,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,417,226.50	2,018,736.82
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,216,296.00</b>	<b>14,223,805.00</b>
210604	Урсгал засвар	14,216,296.00	14,223,805.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,067,216.00</b>	<b>2,906,280.00</b>
210702	Дотоод албан томилолт	8,067,216.00	2,906,280.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,388,429.00</b>	<b>46,417,786.50</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,081,819.00	37,439,820.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	312,390.00	306,504.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,700.00	191,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	32,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,288,000.00	1,938,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,514,520.00	2,508,962.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>13,677,680.00</b>	<b>770,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,927,680.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	770,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>170,736,099.19</b>	<b>256,803,141.58</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>32,780,447.00</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	32,780,447.00	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>26,463,863.00</b>	<b>2,100,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,463,863.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон</b>		

	<b>санхүүжилт, шилжүүлэг</b>	111,491,789.19	254,703,141.58
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,491,789.19	254,703,141.58
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9,218,400.00</u></b>	<b><u>(52,538,527.00)</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,188,000.00</b>	<b>1,200,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,188,000.00</b>	<b>1,200,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>		
222001	Тоног төхөөрөмж	1,188,000.00	-
223001	Бусад хөрөнгө	-	1,200,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,188,000.00)</u></b>	<b><u>(1,200,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	8,030,400.00	(53,738,527.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	117,908,185.00	125,938,585.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	125,938,585.00	72,200,058.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,954,938,118.0	37,522,628.45	22,850,797,749.49	24,843,258,495.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,425,710.59	5,425,710.59
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт	4,587,815,200.0	283,558,334.49		4,871,373,534.49
Тайлант үеийн үр дүн	-	-	(4,287,383,819.09)	(4,287,383,819.09)
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	6,542,753,318.00	321,080,962.94	18,568,839,640.99	25,432,673,921.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн</b>	6,542,753,318.00	321,080,962.94	18,568,839,640.99	25,432,673,921.93

<b>үлдэгдэл</b>				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,413,728,529.92)	(1,413,728,529.92)
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>6,542,753,318.00</b>	<b>321,080,962.94</b>	<b>17,155,275,190.07</b>	<b>24,018,945,392.01</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>125,938,585.00</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>640101600.00</b>	<b>586018682.42</b>	<b>54082917.58</b>	<b>91.6</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>640101600.00</b>	<b>584818682.42</b>	<b>55282917.58</b>	<b>91.6</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>638001600.00</b>	<b>582718682.42</b>	<b>55282917.58</b>	<b>91.5</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	440036880.00	392594643.39	47442236.61	89.2
Үндсэн цалин	332397000.00	290446666.39	41950333.61	87.4
Нэмэгдэл	72421560.00	73283977.00	-862417.00	101.2
Унаа хоолны хөнгөлөлт	35218320.00	28864000.00	6354320.00	82.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	55004640.00	49405538.71	5599101.29	89.8
Тэтгэврийн даатгал	37403160.00	34558706.18	2844453.82	92.4
Тэтгэмжийн даатгал	4400400.00	4063941.80	336458.20	92.4
ҮОМШӨ-ний даатгал	3520320.00	3132113.48	388206.52	89.0
Ажилгүйдлийн даатгал	880080.00	695525.15	184554.85	79.0
Эрүүл мэндийн даатгал	8800680.00	6955252.10	1845427.90	79.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>67271960.00</b>	<b>66753502.00</b>	<b>518458.00</b>	<b>99.2</b>
Гэрэл, цахилгаан	55890800.00	55890800.00	0.00	100.0
Түлш, халаалт	7128000.00	6612702.00	515298.00	92.8
Цэвэр, бохир ус	4253160.00	4250000.00	3160.00	99.9
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9714800.00</b>	<b>9647126.82</b>	<b>67673.18</b>	<b>99.3</b>
Бичиг хэрэг	2367840.00	2344590.00	23250.00	99.0
Тээвэр, шатахуун	5083800.00	5083800.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,063,160.00	2,018,736.82	44423.18	97.8
Ном, хэвлэл	200,000.00	200,000.00	0.00	100.0
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>14,228,740.00</b>	<b>14,223,805.00</b>	<b>4935.00</b>	<b>100.0</b>
Урсгал засвар	14,228,740.00	14,223,805.00	4935.00	100.0
<b>Томилолт, зочны зардал</b>	2,929,560.00	2,906,280.00	23280.00	99.2
Дотоод албан томилолт			23280.00	99.2

Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	2,929,560.00	2,906,280.00		
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>48,040,820.00</b>	<b>46,417,786.50</b>	<b>1623033.50</b>	96.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,060,960.00	37,439,820.00	(1378860.00)	103.8
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,000,000.00	4,000,000.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	356,400.00	306,504.00	49896.00	86.0
Тээврийн хэрэгслийн татвар	538,600.00	191,700.00	346900.00	35.6
Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,700.00	32,000.00	700.00	97.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,150,120.00	1,938,800.00	1211320.00	99.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,384,080.00	-	1384080.00	0.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,517,960.00	2,508,962.50	8997.50	99.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>774,200.00</b>	<b>770,000.00</b>	<b>4200.00</b>	<b>99.5</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	774,200.00	770,000.00	4200.00	99.5
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,100,000.00</b>	<b>2,100,000.00</b>		<b>100.0</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,100,000.00	2,100,000.00		100.0
<b>Хөрөнгийн зардал</b>		<b>1,200,000.00</b>	<b>(1200000.00)</b>	
Дотоодын эх үүсвэрээс		1,200,000.00	(1200000.00)	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	640,101,400.00	640,101,400.00		100.0
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	640,101,400.00	640,101,400.00		100.0
Улсын төсвөөс санхүүжих	640,101,400.00	640,101,400.00		100.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>125,938,585.00</b>	(125938585.00)	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>72,200,058.00</b>	(72200058.00)	
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1		
Төсвийн байгууллага	1	1		
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	42	36	6	85.7
Удирдах ажилтан	2	2		100.0
Гүйцэтгэх ажилтан	28	22	5	78.5
Үйлчлэх ажилтан	12	12		100.0
Гэрээт ажилтан				

3. 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.12	Аудитын нэр: Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/34/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Алтанбулагийн чөлөөт бүс	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажилтнуудын ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүйгээс цалин давхардуулан олгосон.	3,898.1	Төлбөрийн акт тогтоох	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
2	Тооцооны нягтлан бодогч нь 2019 оны 01 дүгээр сараас хойш эд хариуцагчийн үүргийг Хөдөлмөрийн гэрээгүй гүйцэтгэж, анхан шатны баримтууд дээр нягтлан бодогч, олгосон нярав хэсгүүдэд гарын үсэг зурсан зөрчил гаргасан.		Албан шаардлага тогтоох	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
3	Тэтгэвэр тогтоолгосон ажилтнуудад нэмэгдэл хөлс олгосон		Зөвлөмж хүргүүлэх	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
4	Анхан шатны баримтын бүрдлийг хангах		Зөвлөмж хүргүүлэх	Захирагч, ерөнхий нягтлан бодогч	Ж.Амаржаргал Г.Балцэцэг
	<b>Нийт</b>	3,898.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2020 оны 02 дугаар сарын 21

№ 02/05

Улаанбаатар хот

С.т. 2020/34/СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 5 дугаар тогтоолын хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хавсралтад дурдсан ажилтнууд ээлжийн амралтаа биеэр эдлээгүйгээс 3,898,144 төгрөгийн цалинг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 13-т “Ажил олгогч нь ажилтанг ажлаас халагдахаас бусад тохиолдолд болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол биеэр эдлээгүй ээлжийн амралтын оронд мөнгөн олговор олгож болохгүй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилтнуудад давхардуулан олгосон 3,898,144 (гурван сая найман зуун ерэн найман мянга нэг зуун дөчин дөрвөн) төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төв төрийн сангийн 100900000601 тоот дансанд 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Алтанбулагийн чөлөөт бүсийн захирагч Ж.Амаржаргал, ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

**ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
Г.ГҮНЖИДМАА

“ПИЙК ОМ АУДИТ” ХХК-ийн  
АУДИТОР Б.НАРАНЧИМЭГ

**АКТЫГ:**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
АЛТАНБУЛАГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН  
ЗАХИРАГЧ

Ж.АМАРЖАРГАЛ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Г.БАЛЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харгүцагч албан тушаалтанд харгүцага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 21

№ 02/09

Улаанбаатар хот

С.АТ- 2020/34/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрх, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоолын хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Алтанбулагийн чөлөөт бүсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Алтанбулаг чөлөөт бүсийн тооцооны Нягтлан бодогч Ө.Содов нь 2019 оны 01 дүгээр сараас хойш эд хариуцагчийн үүргийг Хөдөлмөрийн гэрээгүй гүйцэтгэж, анхан шатны баримтууд дээр нягтлан бодогч, олгосон нярав хэсгүүдэд гарын үсэг зурсан зөрчил гаргасан байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Нягтлан бодогч эд хариуцагчийн үүргийг гүйцэтгэж байгаа зөрчлийг таслан зогсоож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Алтанбулагийн чөлөөт бүсийн Захирагч Ж.Амаржаргал, ерөнхий нягтлан бодогч Г.Балцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Т.ГҮНЖИДМАА  
"ПИЙК ОМ АУДИТ" ХХК-ийн АУДИТОР

Б.НАРАНЧИМЭГ

ТОГТООСОН:

АЛТАНБУЛАГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН  
ЗАХИРАГЧ

Ж.АМАРЖАРГАЛ  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Г.БАЛЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichir\_Kherel\Alban\_Shaardлага\2020\02\21\565 Docx

0001080034

